



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ**



## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	6
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....	7
2.8.2	Төсвийн ерөнхий захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар .....	8
2.8.3	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	14
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	14
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	15
4.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	17
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
5	Хавсралт.....	20
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарт
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
БНХАУ	Бүгд найрамдах Хятад Ард Улс
АЗЗА	Авто зам завсар арчлал
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



Г ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД  
Б.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.04.25 № 847  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



## Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР С.БҮРЭНБАТ





## **2 Аудитын тайлан**

### **2.1 2.1. Оршил**

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төсвийн ерөнхийлөн захирагч Б.Энх-Амгалан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 4 дүгээр сарын 5-наас 2019 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Сэржмядаг гүйцэтгэв.

ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 03/1556 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх журам,



түүнд тусгасан заавар аргачлалын дагуу үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу үе шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

#### **2.4 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

ЗТХЯ-ны талаарх ерөнхий мэдээллийг А101 маягтаар шинэчлэн баталгаажуулсан болно.

ЗТХЯ-ны эрхэм зорилго нь эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, логистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээний нөхцөлийг бий болгох. Энэхүү зорилтын хүрээнд стратегийн 7 гол зорилтыг хэрэгжүүлэхээр 28 дэд зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

ЗТХС төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмыг мөрдөж байна.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

#### **2.5 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад салбарын хэмжээнд 2016 онд боловсруулж ЗТХС-ын 2017 оны А/28 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна. Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам заавартай нийцэж байна.

ЗТХЯ-ны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм ашиглажээ.

ЗТХЯ-ны үндсэн үйл ажиллагаа, дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.



## 2.6 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгов.

Энэ нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын нийт хөрөнгө дахин үнэлгээтэй холбоотойгоор өөрчлөлт орсон тул нийт хөрөнгийг сонгох нь зүйтэй гэж үзлээ.

ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгө 8,328,179.8 сая төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 83,281.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь эрсдэл дунд, гэж үзсэнтэй холбоотой юм. Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

Дээрх ажлын баримтад материаллаг байдлын суурь үзүүлэлт, хувь хэмжээг сонгосон шалтгаан, тайлбараас гадна чанарын үзүүлэлтийг тусгасан.

## 2.8 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 61 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 60 санхүүгийн тайлан аудитад хамрагдаж 1 санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

Хүснэгт 1 Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр.

/тоогоор/

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	2	2		
2	Төрийн өмчит үйлдвэрийн газар	39	5	1	
3	Төсөл хэрэгжүүлэх нэгж	5	4		
4	Засгийн газрын тусгай сан	1	1		
5	Төсвийн төвлөрүүлэн захирагч	1			
6	Төсвийн ерөнхийлөн захирагч	1			
<b>Дүн</b>		<b>49</b>	<b>12</b>	<b>1</b>	<b>0</b>

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан



Аудитаар 43 санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, 5 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт гаргасан байна. Хязгаарлалттай болон сөрөг дүгнэлт авсан байгууллагууд болон дүгнэлтийн үндэслэлийг дурдвал:

Хязгаарлалттай санал дүгнэлт авсан байгууллагууд:

- ✚ “Монголын төмөр зам” ТӨХК нь Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүхийн 2018 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 001/ХТ2018/01155 дугаар тогтоолоор “Кэй Эйч Эн Ар” ХХК-ийн “Шинэ төмөр замын төсөл”-ийн ажлын гүйцэтгэлд 3,370.4 сая төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн өр төлбөрийн үүргийг санхүүгийн тайланд тусгаагүй, хугацаа хэтэрсэн 51.4 сая төгрөгийн авлага барагдуулах арга хэмжээ аваагүй, нийт 3,421.8 сая төгрөг,
- ✚ Дорноговь аймгийн “АЗЗА” ТӨХК нь үндсэн хөрөнгийн элэгдлийг татварын зорилгоор байгуулаагүйгээс хойшлогдсон татварын хөрөнгийг бүртгэж тайлагнаагүй, санхүүгийн тайлангийн үлдэгдэл дүнгүүдээс нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан болон татварын тайлангуудын дүн зөрүүтэй зэрэг залруулагдаагүй зөрчлийн дүн 31.8 сая төгрөг,
- ✚ Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх төсөл 1 төслийн нэгжийн үйл ажиллагааны зардлыг батлагдсан төсвөөс 272.2 сая төгрөгөөр илүү санхүүжүүлсэн,
- ✚ Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх төсөл 2 төслийн нэгжийн үйл ажиллагааны зардлыг батлагдсан төсвөөс 60,406.3 сая төгрөгөөр илүү санхүүжүүлсэн, ажилтнуудын цалингаас 45.5 сая төгрөгийн ХХОАТ-ыг суутгаж харьяа татварын албанд шилжүүлсэн боловч тайлан гаргаагүй, татвар төлөгчөөр бүртгүүлээгүй, мөнгөн кассын ажиллагааны журам зөрчсөн, 26.8 сая төгрөгийн бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, зарцуулалтыг шууд зардлаар бүртгээгүй, нийт 60,478.6 сая төгрөг,
- ✚ Бүс нутгийн ложистикийг төвийг хөгжүүлэх төслийн үйл ажиллагааны зардлыг батлагдсан төсвөөс 998.8 сая төгрөгөөр илүү санхүүжүүлсэн, төслийн барилгын материал, тоног төхөөрөмжөөс 2016-2018 онд 4,662.3 мянган ам.долларын гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн ба тус чөлөөлөлтийг хөрөнгийн өртөгт оруулж тооцоогүйгээс дуусаагүй барилга дансанд хуримтлуулаан бүртгэж байгаа хөрөнгийг үнэн зөв гэдгийг нотлох боломжгүй, хүүгийн орлого 13.4 сая төгрөгийг журмын дагуу тайлагнаагүй, нийт 1,011.6 сая төгрөгийг алдаа, зөрчлүүд нь тогтоосон материаллаг байдлаас давсан тул хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн байна.

Сөрөг санал дүгнэлт авсан байгууллага:

- ✚ Татварын байгууллагад өгөх 231.6 сая, өмнөх онд гүйцэтгэсэн ажлын үлдэгдэл 160.0 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, 347.9 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн, бараа материал, тоног төхөөрөмжийн сэлбэг, шатахууныг журмын дагуу зарцуулаагүй худалдан авалтын төлөвлөгөөнд батлагдаагүй зарцуулалт гаргасан, 55.0 сая төгрөгийн хөрөнгийг ангилал зөрүүлэн бүртгэсэн зэрэг нийт 1,414.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 754.7 сая төгрөгийг алдааг, аудитын явцад залруулж залруулагдаагүй алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөө тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан тул “Орхон аймгийн “АЗЗА” ТӨХК-д сөрөг санал дүгнэлт өгсөн байна.

**2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл**

ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 119,446.6 сая төгрөгийн алдаа, зөрчил



илрүүлснээс 41.5 хувь буюу 49,604.6 сая төгрөгийн 51 нягтлан бодох бүртгэлийн алдааг аудитын явцад залруулж, 4.2 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 4.4 хувь буюу 5,249.8 сая төгрөгийн 19 зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 54.1 хувь буюу 64,588.0 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх 84 зөвлөмжийг хүргүүллээ.

ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт Алдаа, зөрчил, түүний шийдвэрлэлт. /сая төгрөг/

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс:							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	3	17.0					3	17.0		
2	ТӨҮГ	64	5,357.1	5	3.5	11	2,650.1	48	2,703.6	1	
3	Төсөл, сан	12	91.5			1	45.5	11	46.0		
4	ТТЗ	26	5,687.5	1	0.7	7	2,554.2	18	3,132.6		
5	ТЕЗ	4	58,688.7					4	58,688.7		
<b>Дүн</b>		<b>109</b>	<b>69,842.0</b>	<b>6</b>	<b>4.2</b>	<b>19</b>	<b>5,249.8</b>	<b>84</b>	<b>64,588.0</b>	<b>1</b>	<b>0</b>

Эх сурвалж: 2018 оны Аудит хийсэн санхүүгийн тайлан, хэрэгжүүлсэн горим сорил

### 2.8.2 Төсвийн ерөнхий захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг хэмжээний, анхаарал татахуйц дараах алдаа зөрчилтэй асуудал байна. Үүнд:

- Цалингаас ХХОАТ илүү суутгасан, үр дүнгийн нэмэгдэл илүү олгосон, амралт дутуу бодсон, дээд шатны байгууллагад томилолтын зардал олгосон анхан шатны нотлох баримтгүй зардал гаргасан гэх мэт нийт 4.2 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоосон. /Говь-Алтай аймгийн нисэх буудал 0.7 сая, “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ 1.9 сая, Далайн захиргаа 0.1 сая, Орхон аймгийн АЗЗА ТӨХК 0.5 сая, Сэлэнгэ аймгийн АЗЗА ТӨХК 0.3 сая, Налайх аймгийн АЗЗА ТӨХК 0.7 сая/
- Авлага, өглөг тооцоо нийлж баталгаажуулаагүй, хугацаа хэтэрсэн, төлөгдөх найдваргүй болсон материаллаг дүнтэй, олон жил үргэлжилсэн дуусаагүй хөрөнгө оруулалтын ажилд нэмэлт гэрээ байгуулж дахин санхүүжүүлсэн, үндэслэлгүй ажлаас халагдсан ажилтнуудын нөхөн олговрыг байгууллагаас олгосон, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж биелүүлээгүй, татвар төлөгчөөр бүртгүүлж татварын тайланг гаргаагүй, тооллогоор хөрөнгө дутагдсан зэрэг нийт 5,249.8 сая төгрөгийн зөрчилд 19 албан шаардлага өгсөн. /Иргэний нисэхийн ерөнхий газар 2,554.2 сая, “МИАТ” ТӨХК 2,296.7 сая, “МТЗ” ТӨХК 51.4 сая, Авто тээврийн үндэсний төв ТӨХК 20.6 сая, Далайн захиргаа 1.9 сая, “АЗЗА” ТӨХК-ууд 279.5 сая, Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх төсөл 45.5 сая /

Мөн харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн томоохон зөрлүүдийг дурдвал: Үүнд:

#### Иргэний нисэхийн ерөнхий газрын аудитаар:

- “Үүрэг трейд” ХХК-тай 2018 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр "Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилгын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх" 4,399.9 сая төгрөгийн гэрээг байгуулсан ба гэрээт ажлыг 2018 оны 12 дугаар сарын 20-нд багтаан дуусгахаар тусгасан байна. Тайлант онд гэрээний дүнгийн 84.0 хувь буюу 3,693.9 сая төгрөгийн санхүүжилтийг /1,320.0 сая



төгрөгийг банкны баталгаагаар/ олгож авлагаар бүртгэжээ. Барилгын ажлын 3 удаагийн гүйцэтгэлийн баримтаар 2018 оны эцэст 59.6 хувь буюу 2,621.9 сая төгрөг байгаа ба гэрээнд заасан хугацаанд ажлаа дуусаагүй байна.

- ✚ “Хурдны зам” ХХК-тай 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Завхан аймгийн Доной нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан барих ажлын гэрээний үргэлжлэл, нэмэлт өөрчлөлтөөр 2018 оны 10 дугаар сарын 30-нд ашиглалтад оруулахаар 1,893.7 сая төгрөгийн гэрээ байгуулж нийт 52.0 хувь буюу 1,000.0 сая төгрөгийн санхүүжилт олгож авлагаар бүртгэсэн ба ажлын гүйцэтгэлийн баримтаар 2018 оны эцэст 69.0 хувь буюу 1,306.1 сая төгрөг гарч гэрээнд заасан хугацаанд ажил дуусаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлэн хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.
- ✚ Гадаадын дампуурсан авиа компаниас авах, 1998-2017 онд үүссэн хугацаа хэтэрсэн тооцоо нийлсэн актгүй 2,300.3 сая төгрөгийн авлага санхүүгийн тайланд бүртгэлтэй байгаа зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн аудитаар:

- ✚ БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлэх Сангийн яам, ЗТХЯ-ны хооронд дамжуулан зээлдүүлэх гэрээг 2012 онд 64.3 сая ам.доллараар байгуулсан ба гэрээний бүрэлдэхүүн хэсэг “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний парк шинэчлэл нийлүүлэлт” төслийн нэг хэсэг 6 нэр төрлийн 65 ширхэг 28.6 сая ам.долларын буюу 57,061.8 сая төгрөгийн хөрөнгийн эзэмшигч компанийг тогтоох асуудал шийдэгдээгүй байгаад зөвлөмж өгснийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар үргэлжлүүлэн авч үзсэн.

### **2.8.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 9 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дараа жилийн санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал хандуулах дараах асуудал байна. Үүнд:

БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлэх Сангийн яам, ЗТХЯ-ны хооронд 2012 онд 64.3 сая ам.доллараар байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээнд дараах зөрчилтэй асуудал байна. Үүнд:

- ✚ Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх төслийн 28.6 сая ам.доллар буюу 75,556.8 сая төгрөгийн зээлийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй,
- ✚ Дэд зээлдэгч, эцсийн зээлдэгчийн хооронд гурвалсан гэрээ байгуулаагүй
- ✚ хөрөнгийн эзэмшигч, ашиглагч, өр төлбөрийг төлөх үүрэг бүхий байгууллагыг тогтоогоогүй,
- ✚ 6 нэр төрлийн 65 ширхэг төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний ашиглагдахгүй байгаа 57,061.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж бараа материал дансанд бүртгэлтэй,



- ✚ Мөн дамжуулан зээлийн гэрээгээр хүлээсэн зээл, зээлийн хүүгийн өглөгийг төлж барагдуулаагүй ба Монгол Улсын Засгийн газар 2011-2018 онд хүүгийн төлбөрт санхүүжүүлэгч талд 2.5 сая ам.доллар буюу 5,380.9 сая төгрөгийг төлсөн байна.

Тус хөрөнгийг эзэмшигч, ашиглагч, өр төлбөрийг төлөх үүрэг бүхий байгууллагыг тогтоох асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар дараагийн аудитаар анхаарал хандуулан авч үзнэ.

## **2.10 2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуулиар ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний 2018 онд хэрэгжүүлэх 2 хөтөлбөр 6 арга хэмжээ түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт 384,534.6 сая төгрөг, үүнээс улсын төсвөөс санхүүжих 87,881.6 сая төгрөг, гадаадын зээлийн эх үүсвэрээс 293,582.6 сая төгрөг, тусламжийн эх үүсвэрээс 920.4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,149.9 сая төгрөгийн төсөв батлагдсан ба нийт 427,116.1 сая төгрөгийн санхүүжилт авсан, гүйцэтгэлээр 376,302.8 сая төгрөг буюу 97.9 хувийн биелэлттэй гарсан байна.

Мөн ИНЕГ-ын улсын төсөвт төвлөрүүлэх навигацийн орлогыг 167,672.8 сая төгрөгөөр баталж 100 хувь төвлөрүүлэн ажилласан байна.

## **2.11 2.11. Шилэн дансны мэдээлэл**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудас болон “shilendans.gov.mn” цахим хуудсанд мэдээлж байна.

Тайлант онд Нийцлийн аудитын газрын шилэн дансны аудитаар тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 29, 81, 114, 203, 209, 301 дугаар тушаал болон байгуулсан гэрээний мэдээллийг мэдээлээгүйг зөрчилд нь зөвлөмж өгч ажилласан байна.

## **2.12 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын өмнөх оны аудитаар төсвийн байгууллага 2, хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлан 1, төрийн өмчит үйлдвэрийн газар 21, төвлөрүүлэн захирагч 1, төсөл хөтөлбөр, сан 2, нийт 28 байгууллага 7 төлбөрийн акт, 18 албан шаардлага, 90 зөвлөмжийн биелэлтийг үнэлж холбогдох баримтыг шалгахад зөвлөмж 94.1 хувь, албан шаардлага 85.6 хувь, төлбөрийн акт 95.3 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13 2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын



баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдсан.

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Харьяа газруудад илэрсэн зөрчил**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд 61 санхүүгийн тайлан нэгтгэснээс 49 санхүүгийн тайланд аудитын дүгнэлт өгч төсөл, сан болон хөрөнгө оруулалтын 12 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан, 1 санхүүгийн тайланд итгэл үзүүлснээс, 42 санхүүгийн тайланд зөрчилгүй, 5 санхүүгийн тайланд хязгаарлалттай, 1 санхүүгийн тайлан сөрөг санал дүгнэлт өгсөн байна.

Аудитаар 59,628.2 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 48,477.0 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, 4.2 сая төгрөгийн төлбөрийн 6 акт тогтоож, 5,249.8 сая төгрөгийн зөрчилд 19 албан шаардлага, 5,899.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 80 зөвлөмж хүргүүлсэн байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй, дээд шатны удирдлагын дотоод хяналт сул байх.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Харьяа газруудад өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтийг хэрэгжүүлэн ажиллахад хяналт тавих, зөрчлийг давтан гаргуулахгүй байхад анхаарч ажиллах.

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

#### **3.2 Авлага барагдуулах талаар**



### 3.2.1 Илрүүлэлт:

Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланд 2006-2008 онд үүссэн 24 харилцагч байгууллагатай холбоотой тооцоо нийлсэн актгүй 1,078.1 сая төгрөг, шүүхийн шатанд байгаа 322.9 сая төгрөг, шүүхийн шийдвэртэй боловч барагдаагүй 134.0 сая төгрөгийн авлага тус тус бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 3.2.2 Эрсдэл:

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй, найдваргүй авлага нэмэгдэх, хууль, журам мөрдөгдөхгүй байх.

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах.

### 3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

## **3.3 Хөрөнгө оруулалтын барьцааны өглөгийн талаар**

### 3.3.1 Илрүүлэлт:

Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажил болон барьцаа чөлөөлөх хугацаа дууссан боловч шүүхийн маргаантай 85.0 сая төгрөг, гүйцэтгэгч байгууллагаас барьцаа чөлөөлөх хүсэлт ирүүлээгүй 6.8 сая төгрөг нийт 91.8 сая төгрөгийн барьцаа хөрөнгийн өглөг байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 3.3.2 Эрсдэл:

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй, өр төлбөр ихсэх, хууль, журам мөрдөгдөхгүй байх

### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах

### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

## **3.4 Дамжуулан зээлийн хүрээнд бий болон хөрөнгө, өр төлбөр, эзэмшигч, ашиглалтын талаар**

### 3.1.1 Илрүүлэлт:

